



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ**

2018 оны 12 сарын 10 өдөр

Дугаар 118

Мандалговь

**Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл
олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2017 оны 86 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.5 дахь хэсгийн 4.5.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаас ТОГТООХ НЬ:

Нэг: Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 9,950,000.00 (Есөн сая есөн зуун тавин мянга) төгрөгийн балансын үнэ бүхий тоног төхөөрөмжийг хавсралтын дагуу Дундговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст бүртгэж авахыг зөвшөөрсүгэй.

Хоёр: Дундговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн дарга (Ж.Өлзийжаргал)-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай: Үүнд:

2.1. Комисс томилон хөрөнгө хүлээн авч бүртгэх ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д оруулан бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 12 дугаар сард багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

Гурав: Энэхүү тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (О.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА



С.СҮХБААТАР

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн
 2018 оны... сарын 10-ний өдрийн
 118 дугаар тогтоолын хавсралт



Дундговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн үндсэн хөрөнгөд бүртгэх хөрөнгийн жагсаалт

№	Хөрөнгийн нэр	Марк	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Скайнер	Epson DS 7500	ш	2	3,300,000.00	6,600,000.00
2	Notebook	Acer i5	ш	1	1,540,000.00	1,540,000.00
3	Компьютер	Dell optiplex 7040 i5	ш	1	1,810,000.00	1,810,000.00
НИЙТ ДҮН						9,950,000.00 (есөн сая есөн зуун тавин мянга)